



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 04 сарын 12 өдөр

Дугаар 108

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас
хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1,3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 86 дугаар тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.1, 6.4.3, 6.4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Төв-АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ өртгөө нөхсөн нийт 62,175,745.65 (жаран хоёр сая нэг зуун далан таван мянга долоон зуун дөчин таван төгрөг жаран таван мөнгө) төгрөгийн балансын үнэ, хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. “Төв-АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал М.Ганбаатарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, устгах, сэлбэг, материал хоёрдогч түүхий эд болгон худалдах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2019 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ


Б.ГАНБАТ

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА


А.АРИУНБОЛД

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн ...
2019 дугаар тогтоолын хавсралт

"Төв-АЗЗА" ТӨХК-ийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй акталж, данснаас хасах хөрөнгийн жагсаалт

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалт ад орсон он	Хэм жих нэгж	Тоо хэм жээ	Нэг бүрийн үнэ (төгрөгөөр)	Балансын дүн (төгрөгөөр)	Хуриутлагдсан элэгдэл (төгрөгөөр)	Үлдэгдэл өртөг (төгрөгөөр)
1	Цистерний чиргүүл 2 голт	12/1/1989	ш	1	938,000.00	938,000.00	938,000.00	0.00
2	Усны насос	12/1/2002	ш	1	693,883.33	693,883.33	693,883.33	0.00
3	Усны насос	9/1/2006	ш	2	551,620.00	1,103,240.00	1,103,240.00	0.00
4	Хондо мотор	9/1/2006	ш	1	689,200.00	689,200.00	689,200.00	0.00
5	Хондо мотор	9/1/2006	ш	1	281,200.00	281,200.00	281,200.00	0.00
6	Зөөврийн халуун ус	1/1/1998	ш	1	720,000.00	720,000.00	720,000.00	0.00
7	Усны ёмкость	9/1/2006	ш	1	562,400.00	562,400.00	562,400.00	0.00
8	Нятруулагч 130	6/1/2005	ш	1	6,382,380.00	6,382,380.00	6,382,380.00	0.00
9	Гар индүү НУ-50	6/1/2005	ш	1	10,631,500.00	10,631,500.00	10,631,500.00	0.00
10	Гар витум цацагч	6/1/2005	ш	1	9,866,020.00	9,866,020.00	9,866,020.00	0.00
11	Автомат тоолуур	6/1/2004	ш	1	4,069,500.00	4,069,500.00	4,069,500.00	0.00
12	Хийн доргиурт алх	9/1/2009	ш	1	703,893.00	703,893.00	703,893.00	0.00
13	Хийн компрессор	9/1/2006	ш	1	239,000.00	239,000.00	239,000.00	0.00
14	Трансформатор	8/1/1984	ш	1	30,937.00	30,937.00	30,937.00	0.00
15	Цементний контейнер	1/1/1992	ш	1	108,000.00	108,000.00	108,000.00	0.00
16	Карбин буу	1/1/1999	ш	2	364,950.00	729,900.00	729,900.00	0.00
17	Түмбэний хэв	1/1/1998	ш	1	11,030,324.00	11,030,324.00	11,030,324.00	0.00
18	Км шонгийн хэв	1/1/1998	ш	1	6,120,460.00	6,120,460.00	6,120,460.00	0.00
19	Вагон сууц	1/1/1989	ш	1	347,810.00	347,810.00	347,810.00	0.00
20	Вагон сууц	12/1/1989	ш	1	1,113,312.00	1,113,312.00	1,113,312.00	0.00
21	Вагон сууц	1/1/1991	ш	2	568,866.66	1,137,733.32	1,137,733.32	0.00
22	Вагон сууц	1/1/1991	ш	1	369,600.00	369,600.00	369,600.00	0.00
23	Вагон сууц	2/3/4802	ш	1	1,059,970.00	1,059,970.00	1,059,970.00	0.00
24	Нивелер н3	12/1/2001	ш	1	71,800.00	71,800.00	71,800.00	0.00
25	Тёдолит 2т 5к	12/1/2001	ш	1	115,683.00	115,683.00	115,683.00	0.00
26	Замын дуран	8/1/2004	ш	1	815,000.00	815,000.00	815,000.00	0.00
27	Касио хөгжим	1/1/1999	ш	1	540,000.00	540,000.00	540,000.00	0.00
28	Санхүүгийн программ	6/1/2014	ш	1	1,155,000.00	1,155,000.00	1,155,000.00	0.00
29	Төсөв зохиох программ	6/1/2008	ш	1	550,000.00	550,000.00	550,000.00	0.00
				32		62,175,745.65	62,175,745.65	0.00
	Нийт хөрөнгийн дүн			32 (гучин хоёр)		62,175,745.65 (жаран хоёр сая нэг зуун далан таван мянга долоон зуун дөчин таван тегрөг жаран таван мөнгө)	62,175,745.65 (жаран хоёр сая нэг зуун далан таван мянга долоон зуун дөчин таван тегрөг жаран таван мөнгө)	